

**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10, 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д дараах заалт нэмсүгэй:

1/ Журмын 16.10 дахь заалт:

16.10. Энэ журмын 16.9-т заасан хамтын ХОС-ийн хувьд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компанийн нийт гаргасан хувьцааны 25-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 15-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулж болно.

2. Мөн журмын 16.2.1 дэх заалтын “70 хувиас хэтрэхгүй байх” гэснийг “80 хувиас доошгүй байх” гэж, “25-аас доошгүй гэснийг “15-аас дээшгүй” гэж, 16.2.2 дахь заалтын “зөвхөн нэг салбарт” гэснийг “салбарын нэг дэд салбарт” гэж, 16.4.4 дэх заалтын “нэг салбарт” гэснийг “салбарын нэг дэд салбарт” гэж, 16.9 дэх хэсгийн “16.2.2, 16.4.4-т” гэснийг “16.2.2, 16.2.3, 16.4.4, 16.4.5-т” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН